



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/86

Улаанбаатар хот

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчлэлт түүний хэрэгжилтийг хангах тухай” сэдэвт сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.3, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчлэлт болон бусад тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх сургалтыг 2023 оны 05 сарын 08, 09-ний өдрүүдэд зохион байгуулж, сургалтад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтанд хамрагдсан АЗ гэрчилгээ бүхий иргэд, төрийн албан хаагчид, иргэдийн бүлгийн гишүүдийг хамруулахыг Худалдан авах ажиллагааны алба (О.Содовжамц)-нд үүрэг болгосугай.

2.Худалдан авах ажиллагааны мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийг нэгдүгээр, сургалтад зарцуулагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сургалт зохион байгуулахад шаардлагатай 1,150,000 (Нэг сая нэг зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Сургалтыг чанартай зохион байгуулж, санхүүгийн тайлан мэдээг 2023 оны 05 дугаар сарын 20-ны дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Худалдан авах ажиллагааны албаны дарга (О.Содовжамц)-нд үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
 2023...оны 05 дугаар ... сарын 05 өдрийн  
 А.186 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР  
 БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛТ,  
 ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**


2023 оны 05 дугаар сарын 02

Цаг/мин	Сургалтын агуулга	Зохион байгуулах хэлбэр	Хариуцан чиглүүлэгч
2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр			
10.00-10.10	Нээлт		Албаны дарга О.Содовжамц
10.15-10.40	Худалдан авах ажиллагааны онолын үндэс, эрх зүйн орчин, удирдлага зохион байгуулалтын тухай	Хичээл заах	Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Э.Урансайхан
10.40-11.00	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах тухай		
11.00-11.15	Завсарлага		
11.15-11.30	Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны тухай	Хичээл заах	Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Э.Урансайхан
11.30-12.00	Шинээр батлагдсан тендерийн жишиг баримт бичгүүдийн танилцуулга		
Цайны цаг			
13.30-14.10	Цахим системийн шинэчлэлт, цахим худалдан авах ажиллагааны тухай	Хичээл заах	Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Э.Урансайхан
14.10-15.00	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга		
15.00-15.15	Завсарлага		
15.15-16.00	Асуулт, хариулт		Сургалтанд хамрагдагсад
2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр			
10.00-10.10	Нээлт		Албаны дарга О.Содовжамц
10.15-10.45	Худалдан авах ажиллагааны онолын үндэс, эрх зүйн орчин, удирдлага зохион байгуулалтын тухай	Хичээл заах	Худалдан авах ажиллагаа

10.45-11.20	Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны шинэчилсэн журам, түүний хэрэгжилтийн тухай		хариуцсан мэргэжилтэн Э.Урансайхан
11.20-11.35	Завсарлага		
11.35-12.10	Асуулт, хариулт		Сургалтанд хамрагдагсад
Цайны цаг			
13.30-14.10	Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны тухай		
14.10-14.30	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга		
14.30-14.45	Завсарлага		
14.45-16.00	Асуулт, хариулт		Сургалтанд хамрагдагсад



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023...оны... дугаар ... сарын ... өдрийн  
... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



### СУРГАЛТАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төг)	Нийт үнэ (төг)
1	Дэвтэр	100 хүн	5000	500,000
2	Бал	100 хүн	450	45,000
3	Ус	150 хүн	750	112,500
4	Кофе, цай	150 хүн	900	135,000
5	Жигнэмэг	150 хүн	1450	217,500
6	Нэг удаагийн аяга	300ш	150	45,000
7	Принтерийн хор /тараах материал олшруулах/	1 ш	75,500	75,500
8	Бичгийн цаас	1 боодол	19,500	19,500
	Нийт			1,150,000